МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ **МОНГОЛЫН МЭДЭЭ**

Хүн ам 3,106.005... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.09.20. Мягмар. №167 (4537) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Ц.ДАШДОРЖ: МОНГОЛД ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖИЛ ХИЙГДЭЭГҮЙ МАШ ИХ ХЭМЖЭЭНИЙ ТАЛБАЙ БИЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

УЛС ТӨР

## Ж.МӨНХБАТ: МОНГОЛ УЛС 2030 ОНД НЭГ ХҮНД НОГДОХ ОРЛОГООРОО ТЭРГҮҮЛНЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

## ПРИУС ОСОЛДОЖ, МОНГОЛЧУУД АМИА АЛДСААР Л...

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# МОНГОЛЫН ХӨРСӨНД Ч ХОРТОЙ НОГОО УРГАЖ БАЙНА УУ

Н.БОЛД

Хамгийн аюулгүй хүнс, экологийн цэвэр бүтээгдэхүүн Монголд л байгаа гэж бид цээжээ дэлдэх дуртай. Тийм ээ, манайд экологийн цэвэр хүнс бий. Бид “жаргалтай мал”-ын мах идэж байгаа. Химийн бодистой тэжээл идээгүй, бэлчээртээ дураараа бэлчиж, өвсний соргог, усны цэнгэгийг ууж байгаа малын мах идэж байгаа бид экологийн цэвэр хүнс хэрэглэж байна гэж хэлэхгүй яах юм. Тийм малынхаа цагаан идээг идэж, айраг, цагааг нь ууж байгаа юм чинь цэвэр гэж цээжээ дэлдэхгүй яадаг юм бэ. Монголын газар шороо ч гэсэн элдэв химийн бордоонд хордчихоогүй, атар онгоноороо байгаа. Ийм хөрс шороонд ургасан үр тариа, хүнсний ногоо ч гэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн. Тийм үр тариагаар хийсэн гурил, гурилан бүтээгдэхүүн ч гэсэн сайхан л байж таарна. Бид ингэж л өөрсдийгөө хөөргөж ирсэн. Өмнөд хөршөөс нэг хэсэг хүнсний ногоо зөөдөг байсан.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

## Сурагчдын сэтгэлзүйд сөрөг дайралт хийе

Б.ДАВАА

Хүүхдийн сэтгэхүй гэдэг цав цагаан цаас шиг. Тэрхүү цаасан дээр амьдралын явцад юу бичихээс хамаарч, тухайн хүүхэд ирээдүйд хэн болох нь шийдэгддэг гэдэг. Хүний ухамсарт үйл ажиллагааны онцлог, сэтгэцийн төвшинг тодорхойлогч хүчин зүйл нь нас. Нас ахих тусам хувь хүний оюун ухаан, сэтгэх үйл явцын цар хүрээ улам сайжирч өөрийн үйл ажиллагааны мөн чанар, гарах үр дагаврыг ухамсарлан ойлгох, удирдах чадвар улам нэмэгддэг байх юм. Тэгвэл сүүлийн үед энэ чадвар нь бүрэн бүрэлдэж амжаагүй насанд хүрээгүй хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох нь ихэсчээ. Шулуухан хэлэхэд зөвхөн насанд хүрээгүй хүүхдүүд гэлтгүй 1990-ээд оноос хойш төрсөн залуус гэмт хэрэгт холбогдох нь ихэссэнийг ар араасаа хөврөх бараан мэдээллүүд бэлхэнээ гэрчилнэ.

Үргэлжлэл нь II нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



## Багш, сурагчдыг гар утас ашиглахыг хориглолоо

Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн үеэр багш, сурагчдыг гар утас ашиглахыг хориглосон тушаал Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайд гаргажээ. Уг тушаал ирэх сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжих юм байна. Одоогийн байдлаар төрийн болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудад албан тоот хүргүүлээд байгаа гэдгийг тус яамны хэвлэлийн ажилтан хэллээ.

Өмнө нь, Сонгинохайрхан дүүргийн ИТХ-аас үүнтэй ижил тогтоол гаргаж дүүргийнхээ хэмжээнд ЕБС-ын сурагчдыг ухаалаг утас хэрэглэхийг хориглож байсан билээ. Мөн хотын дарга Су.Батболд ч саяхан сургуулийн орчинд ухаалаг утасны хэрэглээг хэрхэн зохицуулах тухай олон нийтийн саналыг твиттерээр дамжуулан авсан юм.Бага насны хүүхэд гэлтгүй бүх хүний эрүүл мэндэд гар утас, компьютер хортойгоор нөлөөлж буйг сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгаанууд тодорхой харуулж буй. Тухайлбал судалгаагаар ухаалаг утас нь хүүхдийн сурлага, анхаарлаа төвлөрүүлэх чадварт муугаар нөлөөлж, дүнг эрс муутгаж буйг хөгжилтэй орнууд аль хэдий нь тогтоосон. Гэхдээ гар утас хориглох болсон шалтгаан нь зөвхөн хүүхдийн сурлага хүмүүжил төдийгүй эрүүл мэндтэй нь ч холбоотой гэдгийг албаныхан онцолж байна. Ухаалаг утас, компьютер, таблетын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр нүдний дижитал ачаалал хэмээх орчин үеийн хүмүүст ихээхэн тусч буй шинэ өвчний тохиолдол нэмэгдэж байгаа аж.




“ШИНЭ ТӨГӨЛ” ЦЭЦЭРЛЭГТ

ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн “Шинэ төгөл” цэцэрлэг “Маршал таун” хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. “Шинэ төгөл” цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**



Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдгаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО

Холбоо барих утас: 99094864

| | ХААН банк Авах | ХААН банк Зарах | | ХААН банк Авах | ХААН банк Зарах | | Худалдаа хөгжлийн банк Авах | Худалдаа хөгжлийн банк Зарах | | Худалдаа хөгжлийн банк Авах | Худалдаа хөгжлийн банк Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2240.00 | 2255.00 | ФУНТ | 2875.00 | 2968.00 | АМ.ДОЛЛАР | 2240.00 | 2253.00 | ФУНТ | 2885.00 | 2972.00 |
| ЕВРО | 2473.00 | 2540.00 | РУБЛЬ | 33.20 | 36.10 | ЕВРО | 2473.00 | 2548.00 | РУБЛЬ | 33.41 | 36.42 |
| ИЕН | 21.71 | 22.26 | ЮАНЬ | 335.80 | 338.90 | ИЕН | 21.61 | 22.35 | ЮАНЬ | 335.50 | 339.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

## Ерөнхийлөгч Гаванагийн их сургуульд лекц уншлаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд найрамдах Куба улсад албан ёсны айлчлал хийж буй. Тэрбээр айчлалын хүрээнд БНКУ-ын Төрийн Зөвлөл болон Сайд нарын Зөвлөлийн дарга Раул Кастротай албан ёсны хэлэлцээ хийж, "Генетикийн инженер, биотехнологийн төв"-д нь зочилсон юм. Харин өчигдөр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Гаванагийн Их сургуулийн багш, оюутнуудад лекц уншлаа.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өмнө нь Монголын ардчиллыг хөгжүүлж буй туршлага ололт амжилт, хүндрэл бэрхшээл, сорилтын талаар БНАСАУ-ын Ким Ил Сений нэрэмжит их сургууль, Мьянмарын Янгоны их сургууль, Унгарын Европын их сургууль зэрэг хэд хэдэн сургуулиудад лекц уншиж байсан билээ. Дашрамд дуулгахад, Монгол, Куба хоёр улсын улс төрийн харилцаа 1960 оны 12 дугаар сард дипломат харилцаа тогтоож, 1962 онд харилцан бие биеийн нийслэлд ЭСЯ-аа нээснээр эхэлсэн байдаг.




# Ж.МӨНХБАТ: МОНГОЛ УЛС 2030 ОНД НЭГ ХҮНД НОГДОХ ОРЛОГООРОО ТЭРГҮҮЛНЭ

Ж.МЯГМАР

"Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааныүндэснийтөлөвлөгөө"-г олон нийтэд танилцууллаа. Энэ арга хэмжээнд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Нээлттэй засгийн Үндэсний зөвлөлийн дарга Ж.Мөнхбат, Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан суурин төлөөлөгч Жеймс Андерсон, Ази номхон далайн бүсийн иргэний нийгмийн зохицуулагч Шреяа Басу нар оролцлоо.

Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөх эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд чинээлэг дундаж давхарга давамгайлсан улс болох гэнэ. Түүнчлэн экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, ардчилсан засаглалтай улс болохоор зорьж байгаа талаар нээлттэй засаг түншлэлийн дэмжигч байгууллагуудын төлөөллүүд онцолж байлаа.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат "Монгол Улс Олон Улсын Нээлттэй засгийн түншлэлд өгсөн үүрэг амлалт бүхий анхны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудаас "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах", "Байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй аливаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод мэдээлэх" зэрэг шинэчлэлийг хийж чадсан хэмээн сайшаагдаж "Од" үнэлгээ авч, Азидаа үлгэр жишээ болсон" гэлээ. Мөн тэрбээр "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гол зорилт нь улс орны эдийн засгийг богино хугацаанд сэргээж, өсөлтийг бий болгоно. Түүнчлэн нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ аж амьдралыг сайжруулахаас гадна төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн, улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн" гэдгийг онцоллоо.

Нээлттэй засгийн түншлэл нь гишүүн орнуудаа нээлттэй, иргэдийн оролцоог дэмждэг, авлигын эсрэг тэмцдэг, үр ашигтай, хариуцлагатай Засгийн газрыг бий болгох зорилго бүхий Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагын сайн дурын хамтын ажиллагааны олон улсын санаачилга юм. Таван жилийн өмнө 2011 онд НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хурлын үеэр албан ёсоор байгуулж байсан Нээлттэй засгийн түншлэлд өдгөө дэлхийн 70 орон, мянга мянган иргэний нийгмийн байгууллагууд, болон олон улсын дэмжигч байгууллагууд нэгдэж, хамтдаа 3000 гаруй үүрэг амлалтыг Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөгөөр дамжуулан өгч, хэрэгжүүлж байгаа юм. Дашрамд дуулгахад, Монгол Улс Нээлттэй засгийн түншлэлд 2013 онд нэгдэн орсон байдаг юм.

## "Оюутолгой" компанийн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлжээ

"Оюутолгой" компанийн ТУЗ-ийн Монголын талын гишүүд болох Б.Бямбасайхан, Д.Ганболд, Ч.Отгочулуу нарыг чөлөөлжээ. Өнгөрсөн баасан гарагийн орой "Эрдэнэс Монгол" компанийн ТУЗ хуралдаж уг шийдвэрийг гаргасан байна. "Оюутолгой" компанийн ТУЗ-д Монголыг төлөөлж бай-сан хүмүүст энэ талаар албан ёсоор мэдээлээгүй байгаа аж. Гэхдээ маргааш "Эрдэнэс Монгол" компани болон "Оюутолгой" компанийн ТУЗ хуралдах тов гарчээ. Энэхүү ТУЗ-ийн хурлаар Гүйцэтгэх захирал Б.Бямбасайханыг чөлөөлж, шинэ захирал томи-лох асуудлыг хэлэлцэж магадгүй байна.

## Сонгуульд 15209 нэр дэвшигч өрсөлдөнө

Сум, дүүргийн ИТХ-ын сонгууль ирэх аравдугаар сарын 19-нд болно. Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулах хуваарийн дагуу аймаг, дүүргийн сонгуулийн хороод нэр дэвшигчдээ бүртгэж дууссан. Нийслэлийн есөн дүүрэг, 21 аймгийн 330 гаруй сум 1792 тойрогт хуваагдсан бөгөөд нийт 7006 мандатын төлөө 15209 хүн өрсөлдөхөөр бүртгүүлжээ. Өөрөөр хэлбэл, 15209 нэр дэвшигчийн 7006 нь сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдох юм. Хамгийн олон сумтай аймгууд болох Төв аймагт 1107, Хөвсгөл аймаг 1100 хүн 500 гаруй мандатын төлөө өрсөлдөх юм байна. Сонгуулийн хороод нэр дэвшигчдийн үнэмлэхийг санал хураалт явуулах өдрөөс 22 хоногийн өмнө буюу энэ сарын 29-ний дотор олгож дуусах аж. Нэр дэвшигчид сурталчилгаагаа аравдугаар сарын 1-нээс эхлүүлнэ.

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Дугаарын 60 мөр

# Сурагчдын сэтгэлзүйд сөрөг дайралт хийе

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Чөлөөт нийгэм бүрэлдэн тогтож, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд оноос хойш импортын олон соёлын нөлөөнд хүүхэд, өсвөр үе ямар нэг шүүлтүүргүйгээр хэт автсан нь эцэстээ ийм үр дагаварт хүргэв үү. Аллага хүчирхийлэл, садар самуун сурталчилсан кино уран бүтээл, Солонгосын олон ангит киноны нөлөө, интернэт, нийгмийн сүлжээний хэт буруу хэрэглээ өсвөр үеийнхнийг хэн болгон хувиргаж байгааг бид нүдээрээ харж, мэдэрч ирлээ. Тиймдээ ч ийм дүгнэлт хийхэд хүрсэн хэрэг. Гэрийн ажилд гар бие оролцон эцэг эхдээ туслах, эсвэл даалгавраа хийж, үеийн жаахан хүүхдүүдтэй гадаа хөөцөлдөн тоглох насан дээрээ PC тоглоомын үүдийг сахиж, гадуур хоноглон алаан хядаан цус урсгасан тоглоомонд улайран суух нэгнийг ирээдүйд хэн болохыг нь үнэндээ хэн ч тааварлаж чадахгүй шүү дээ. Цагдаагийн байгууллагаас гаргасан нэгэн баримтыг дурьдахад, энэ оны эхний таван сарын байдлаар насанд хүрээгүй хүүхэд үйлдсэн 215 гэмт хэрэг бүртгэгдсэний 58.4 хувь нь нийслэлд гарчээ. Үүнээс 14-15 настай 47, 16-17-той 180 хүүхэд байгаа юм. Эдгээрийн 45.6 буюу 98 нь хулгайлах, 55 буюу 25.5 хувь нь бусдын биед гэмтэл учруулсан хэрэг эзэлж буй. Мөн энэ оны эхний таван сарын байдлаар газ үнэртэж мансуурсан найман хүүхэд бүртгэгдсэний нэг нь хорвоогоос хальсан байдаг. Хамгийн сүүлийн үеийн жишээ дурьдахад ч, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт өвс татаж мансуурсан 18 настай хүү хүргэгдэн ирж, улмаар амиа алдсан харамсалтай хэрэг энэ сарын 12-нд гарсан байх юм. Гэмт хэргийн талаарх мэдээллийг урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах зорилгоор хэвлэлийнхэн ч сайтар мэдээлэх авч, заримдаа сэргийлэх бус сэдэл өгч орхидог тухай албаны нэгэн эрхэм дурьдаж байсныг энд дурьдахад илүүдэхгүй биз. Тэгвэл гэмт хэрэг үйлдсэн хойно нь хашгичих бус, үйлдэхээс нь өмнө сэргийлэхэд нэмэр болохуйц нэг санал байна. Хар тамхины эсрэг дайн зарласан Филиппиний шийтгэгч хочит Ерөнхийлөгч Родриго Дютертын хэрэгжүүлж буй бодлогоос бидний нөхцөлд уусгаж болохуйц нэгэн туршлага байгаа нь сургуулийн сурагчдыг шоронтой танилцуулах үйл ажиллагаа юм. Улсын хууль цаазыг уландаа гишгэж, гэмт хэрэг үйлдвэл ийм шийтгэл хүлээж, ийм орчин нөхцөлд хоригдох болно гэдгийг Филиппиний боловсролын байгууллага хийгээд хуулийнхан багаас нь харуулж мэдрүүлэх зорилгоор сурагчдыг шоронтой танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг болж. Нэг талаар, энэ нь хүүхдийн сэтгэл-зүйд нөлөөлөх сөрөг дайралт юм. Алаан хядаан цус урсгасан эсвэл хүчирхийлэл, хар тамхины хэрэглээг сурталчилсан барууны киноноос хүүхдүүд гэмт хэргийг энгийн зүйл мэт хүлээн авсан байх нь бий. Тэгвэл тэдний ийм сэтгэхүйд сөрөг дайралт хийж, гэмт хэрэг үйлдвэл хуулийн хариуцлага хүлээж, эрхээ хязгаарлуулдаг юм шүү гэдгийг бодит нөхцөл дээр нь тулгуурлан ой тойнд нь ухааруулдаг болъё. Хамгийн гол нь орчныг нь харуулдаг байя. Номонд бичсэн онолын мэдээллээс илүүтэй бодит орчин хүүхдийн сэтгэхүйд илүү нөлөөтэй байх болов уу. Тиймээс цагдаагийнхан болон боловсролын салбарынхан хамтран эх орны ирээдүй болсон залуу үеэ гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ийм сөрөг дайралт хийгээд үзвэл ямар вэ.

## Ю.Цэдэнбал агсны цол тэмдгийг буцаан олголоо

Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол, Ой тэмдэглэх тухай Засгийн газрын 333 дугаар тогтоолын хүрээнд зохион байгуулах комисс байгуулагдаж, арга хэмжээ зохион байгуулж байгаа билээ. Тэгвэл түүний 100 жилийн ойн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны наймдугаар сарын 25-ний өдөр тушаал гаргажээ. Энэхүү тушаалаар Улсын банкны ерөнхий хорооны даргын 1990 оны наймдугаар сарын 08-ны өдрийн 3/247 дугаар тушаалыг хүчингүй болгосон байна. Үүний дараа Ю.Цэдэнбал агсны "Санхүү банкны тэргүүний ажилтан" цол тэмдгийг буцаан олгож, "Монголбанкны Хүндэт дэвтэр"-т бичиж түүний гавьяаг алдаршуулсан буй ажээ.

# Д.Сүхбаатарын талбайн нэрийг сэргээсэн нь улс төрийн оролцоогүй гэв




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Жанжин Д.Сүхбаатарын талбайн нэрийг өнгөрсөн долоо хоногт НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар эргэн сэргээсэн билээ. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн МАН-ын дэд дарга С.Мөнхчулуун, жанжин Д.Сүхбаатарын гуч З.Хайдар нар хэвлэлийн хурал хийлээ. МАН сонгуульд ялснаас болж талбайн нэрийг сольсон гэдэг нь ташаа мэдээлэл болохыг Нийслэлийн МАН-ын дэд дарга С.Мөнхчулуун хэллээ. Түүнчлэн Д.Сүхбаатарын гуч иргэн З.Хайдар "НИТХ- ын Тэргүүлэгчдийн 2013 оны 79 дүгээр тогтоолоор Жанжин Д.Сүхбаатарын талбайн нэрийг Их Эзэн Чингис хааны нэрэмжит талбай болгон өөрчилсөн. Энэхүү тогтоолыг хууль бус гэж үзэн Миний бие 2015 онд Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлийн дагуу гурван шатны шүүх дээр маргаан бүхий тогтоолыг хянан хэлэлцээд шийдвэрээ гаргасан. Шүүхийн шийдвэрээр НИТХ-ын 79 дүгээр тогтоолыг хууль бус гэж үзэн, Их жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайн нэрийг сэргээсэн юм. Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх 2016 оны наймдугаар сарын 16- ны өдрийн 573 дугаар тогтоолоор нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснөө баталсан болно. Иймд дээрх анхан шатны шүүхийн тогтоолын дагуу Д.Сүхбаатарын талбайн нэрийн эргэн сэргээхээр болсон. Энэ асуудалд ямар нэгэн улс төрийн нам, эвслийн оролцоо, ашиг сонирхол байхгүй" гэлээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

# МОНГОЛЫН ХӨРСӨНД Ч ХОРТОЙ НОГОО УРГАЖ БАЙНА УУ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин сүүлийн жилүүдэд хүнсний аюулгүй байдал ярьж, цаашлаад газар тариалангийн салбараа сайтар дэмжсэнээр гаднаас төмс, хүнсний ногоо зөөх нь багассан. Хэтрүүлж ярьвал өмнөд хөршөөсөө ширхэг төмс ч оруулж ирэхгүй байгаа. Дархан, Сэлэнгэ, Төв аймагт толгойтой болгон төмс, хүнсний ногоо тарьж байна. Цаашлаад говийн аймгууд, баруун, зүүн хязгаарт ч ногоо тарьж байгаа. Энэ яах аргагүй сайн хэрэг. Гэвч сайнаа дагаад саар нь ч бас гараад байна. Учир юу гэвээс, Дархан, Сэлэнгэ, Төв аймгийн нутагт их хэмжээгээр төмс, хүнсний ногоо тариалж байгаа иргэд өөрсдөө хүнсний аюулгүй байдлаа “алж” байна. Ингээд бичихээр яг таг мэдэж байгаа юм шиг хандлаа, биднийг гүжирдлээ, гүтгэлээ л гэх байх. Тэгвэл ганц хоёрхон жишээ татъя. Аав минь ногоо тарьдаг, тариаланч хүн. Өвөрхангай аймагт гэдгийг тодотгоё.Тариалангийнсалбарт хутгалдаж яваа болохоор энд тэндхийн ногоочидтой байнга уулзалдана. Гэтэл саяхан Дархан-Уул аймгийн Орхон суманд ногоо тарьдаг нэг залуутай уулзаж л дээ. Өнөөх нь “Ах минь, энүүхэндээ гэж хэлэхэд, манай суманд бүх айл ногоо тарьдаг. Өөрсдөө идэх ногоогоо хашаандаа тарина. Харин том талбайд тарьж байгаа ногоогоо химийн бордоогоор бордоод, томсгох бодис хийгээд л ургуулдаг. Хурдан, том ургуулаад, шуудайгаар нь бөөндөөд л зарна шүү дээ” хэмээн ярьсан байгаа юм. Дахиад нэг жишээ байна. Манай нэг төрөл Төв аймгийн Цээл сум буюу Залуучуудын сангийн аж ахуйд амьдардаг юм. Бас бага сага ногоо тарина аа. Гэтэл идэх хүнсний ногоогоо Өвөрхангайгаас авна гэж ярьж байна. Тэр хавиар нь дүүрэн ногоо тарьж байгаа хүн байхад аймаг алгасаж идэх хүнсний ногоогоо авч байгаагийн учрыг асуухад “Манай энд өөрсдөө идэх ногоо байхгүй ээ” гэж билээ. Бас л ногоогоо эрт бөгөөд томхон ургуулаад, хот руу шуудай шуудайгаар нь бөөнддөг юм гэсэн. Тэнд килограммаар нь зарна гэсэн ойлголт байхгүй. Шуудай төмс 10, шуудай байцаа 5000 төгрөг гээд л зарчихдаг. Халуун зунаар шахуу, наймдугаар сарын эхээр л шинэ ургацын ногоо гээд гараад ирдэг. Гэтэл яг наймдугаар сарын эхээр төмс, хүнсний ногоо том том ургаж гүйцэх бил үү. Яах вэ, эрт ургацын сорт гэж байгаа. Гэхдээ л наймдугаар сар гарахтай зэрэгцээд л том том ургаад байдаг нь бас юу л бол. Үүний ард нөгөө л хурдан, том ургуулдаг химийн бодисны нөлөө байгаа юм. Зөвхөн төмс, хүнсний ногоо ч гэлтгүй тарвас, жимсийг ч манайхан химийн бодисоор бордож, хурдан болгож, ургуулаад байна гэж хардахгүй бол болохгүй нь. Ховд аймаг руу томилолтоор явсан юм. Тэр энэ гээд яахав, нэг жишээ л татах гээд байна. нам засгийн томчуудтай л сэтгүүлчид явдаг шүү дээ. Гэтэл Ховдын захиргааныхан тарвас авчрахаар явахдаа “Өөрсдийнхөө иддэгээс авчрах юм уу” гэж асууж байсан гэдэг юм. Харин дарга нар нь “Сайд, дарга нар ирж байгаа юм чинь өөрсдийнхөө иддэгээс л авчирсан нь дээр” гэж хариулж. Энэ жишээ юу өгүүлэв. Бас л тарвасаа ургуулахдаа хоёр ангилдаг байх нь байна. Зах зээлд гаргаж зардаг тарвасаа болохоор химийн бодисоор бордож ургуулдаг. Өөрсдийн идэхээ болохоор бордоогүй ургуулдаг гэсэн үг болж таарах гээд байгаа юм. Бид Өмнөд хөршөөс хамаг л хортой хүнсний бүтээгдэхүүн орж иж байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдлаа. Ядаж л идэж уухаа өөрсдөө үйлдвэрлэдэг болъё гээд л байдаг. Гэтэл яг начир дээрээ өөрсдөө хүнсний аюулгүй байдлаа үгүй хийгээд байгаа юм биш үү. Мэдээж төмс, хүнсний ногооны нийлүүлэлт зах зээлд ихсээд, айлууд хашаандаа хэрэгцээнийхээ ногоог тариад байхаар үнэ унаж л таараа. Статистикийн газраас өнгөрсөн жилийн энэ үетэй харьцуулахад хүнсний ногооны үнэ 20 хувь унасан гэсэн тоо хэлээд байгаа. Тоон мэдээллээс үзвэл 2015 оны наймдугаар сард төмс 1400 орчим төгрөгийн үнэтэй байж. Харин энэ жилийн наймдугаар сард 1000 төгрөг л байлаа. Одоо бол бүр 500 төгрөг рүү ороод ирчихсэн. Гэтэл 2-3 жилийн өмнө монгол төмс ямар үнэтэй байлаа даа. Ингээд бодохоор жил ирэх тусам төмс, хүнсний ногооны үнэ буурч байна. Гэтэл тариаланчид үнийн уналтын энэ “шуурга” дундаас ашиг олох гэж зүтгэж, сүүлдээ экологийн цэвэр бүтээгдэхүүнийг хордуулж эхэллээ. Хурдан хугацаанд, томхон ургуулаад, шуудай шуудайгаар нь хямд зарж, ашиг олох л арга хайж байна. Энэ чинь л хүнсний аюулгүй байдалд нөлөөлж байна шүү дээ. Цаашлаад ногоогоо бордсон бордоо, химийн бодис нь хүний биед яаж нөлөөлөхийг хэн мэдлээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

> ...Харин том талбайд тарьж байгаа ногоогоо химийн бордоогоор бордоод, томсгох бодис хийгээд л ургуулдаг. Хурдан, том ургуулаад, шуудайгаар нь бөөндөөд л зарна шүү дээ” хэмээн ярьсан байгаа юм. Дахиад нэг жишээ байна. Манай нэг төрөл Төв аймгийн Цээл сум буюу Залуучуудын сангийн аж ахуйд амьдардаг юм. Бас бага сага ногоо тарина аа...



## УЛС ТӨР

САЙД ЯРЬЖ БАЙНА

# Ц.ДАШДОРЖ: МОНГОЛД ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖИЛ ХИЙГДЭЭГҮЙ МАШ ИХ ХЭМЖЭЭНИЙ ТАЛБАЙ БИЙ



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Ч.ЧУЛУУН

*Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржтой ярилцлаа.*

**-Шинэ Засгийн газар уул уурхай, хүнд үйлдвэр гэдэг хоёр том салбарыг нэг яамд харьяалуулж, нэгдсэн бодлогоор зангидаж явахаар боллоо. Үүний үр дүнг та яаж харж байна вэ?**

-Өмнө нь Аж үйлдвэрийн яам байхад хөнгөн, хүнд бүх үйлдвэрүүд бүгд нэг дээвэр дор явж ирсэн. Энэ Засгийн газрын үед хөнгөн, хүнд үйлдвэрийн бодлого тусдаа саллаа. Монголд шинээр бий болж байгаа, ирээдүйд бий болох хүнд үйлдвэрүүд маань үндсэндээ уул уурхайн баялагт түшиглэж байна. Уул уурхай ярихаар хайгуул хийх нь гэж ойлгох хүмүүс байна. Ашиглалт ярьдаг хэсэг ч байна. Нэмүү өртөг бий болгодог боловсруулах үйлдвэрүүд бас бий. Энэ бүгдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нэг бодлогоор уялдуулж авч явах ёстой байх нь. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалыг эрэх хайхаас эхлээд эдийн засгийн үр ашгийг зөв тооцсон олборлох үйл ажиллагаа, дараачийн боловсруулах үе шатыг энэ яам төрийн бодлогоор уялдуулах нь. Монгол Улс цөөн тооны зах зээлд ашигт малтмалаа гаргаж байна. Дийлэнх нь урд хөрш рүү гарч байна. Эрэлт хаана байна, ямар байнагэдгээсшалтгаалжсалбарын бодлого тодорхойлогдоно. Гэхдээ бидэнд боломж байна. Энэ боломж бол Монгол Улс ямар баялагтай вэ гэдгээ олж илрүүлэх явдал. Энэ баялгийг олж илрүүлэх ажлыг гадаад, дотоодын хайгуулын компаниуд хийдэг. Төрөөс тодорхой хэмжээний санхүүжилтээр хайгуулын ерөнхий дүр зургийг гаргаж өгдөг ч энэ бол өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа. Тиймээс энэ ажлыг ихэвчлэн хувийн компаниуд эрсдлээ үүрээд хийж байна. Харин төрөөс хайгуулын үйл ажиллагааг шударга бөгөөд оновчтойгоор явуулах бололцоог нь бүрдүүлж өгөх ёстой. Монголын газар нутагт геологи хайгуулын ажил иж бүрнээрээ хийгдээгүй маш их хэмжээний талбай байна. Манай газрын хэвлийд ямар баялаг байна, тэдгээрийг бид улс орныхоо ирээдүйн хөгжилд ашиглаж болох уу, үгүй юу гэдгийг бид мэдэх шаардлагатай. Энэ бол манай яамны бодлогоор тодорхойлох ёстой нэг салбар мөн. Өмнө нь хайгуулын лиценз шинээр өгөхийг хориглосон байсан боловч өнгөрсөн жилээс зөвшөөрөгдөөд, холбогдох агентлаг нь хайгуулын лиценз олгоод эхэлсэн. Энэ үйл ажиллагаа зөв, шударга явснаар энэ салбарт хөрөнгө оруулалт орж ирэх зам нээгдэнэ. Түүхий эдийн үнэ унахад хайгуулын үйл ажиллагаа саармагждаг. Үнэ өсвөл эргээд сэргэдэг. Үндсэндээ сүүлийн жилүүдэд эрдэс баялгийн гаралтай түүхий эдийн үнэ унасан. Энэ салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан. Дээр нь Монгол Улсын хайгуулын лиценз шинээр олгохгүй байх, бусад хууль тогтоомжоо чангаруулах, ойлгомжгүй болохоос эхлээд нөлөөлсөн юм бий. Гэхдээ энэ цикль маань эргээд өсч таарна. Түүхий эдийн эрэлт нэмэгдэнэ. Энэ идэвхжил сэргэх үед харин манай улс хууль тогтоомжийн хүрээнд болон тусгай зөвшөөрөл олгох процедураа нээлттэй, ил тод болгох ёстой. Тэгж байж гадаад, дотоодын хөрөнгө оруууулагчид энэ салбарт орж ирнэ. Хайгуулын 1000 лицензээс таван хувь нь л эдийн засгийн үр ашигтай томоохон үр ашиг бүхий орд байх магадлал статистикийн хувьд байдаг. Монголд хайгуулын хэчнээн лицензийг шинээр олгож байна, өмнө нь хэдийг олгосон бэ гэдгийг тооцоод үзвэл эдийн засгийн үр ашигтай томоохон орд хэд байх вэ гэдэг тооцоо гараад ирнэ. Ихэнх ордууд социализмын үед хайгуулын нөөц нь урьдчилан тогтоогдчихсон байгаа, ялангуяа нүүрсний хувьд. Ардчиллын 20 гаруй жилийн хугацаанд Оюутолгойн ордыг эдийн засгийн үр ашигтай гэдгийг нь тогтоосон. Өмнө нь тэнд илэрц байна л гэж үзэж байсан бол өнөөдөр орд юм гэдгийг нь нотолсон. Түүнээс өөр төмөрлөгийн, нүүрсний ямар орд олов гэдгээ бид өөрсдөө тооцоод хэлчих боломжтой. Хайгуул хийж, нөөц тогтоох, энэ салбарт хөрөнгө оруулалт татахад дэлхий дахинд байгаа түүхий эдийн үнэ ханш нөлөөлөхөөс гадна манай улсын өөрийн хууль тогтоомж нөлөөлнө. Энэ ажилд яам бодлогоо төвлөрүүлж байна. Хайгуулын явцад маш цөөхөн нь орд болж хувирна. Үүн дээр ямар бодлого баримтлах вэ, хэн энэ ордыг хэн худалдаж авах вэ, олборлолт явуулсны дараа бүтээгдэхүүнээ өрсөлдөхүйц үнээр нийлүүлж чадах уу гэдэг ч бас бодлого. Хэрвээ чадахгүй бол эдийн засгийн үр ашиггүй орд болно. Манайхаас илүү дэд бүтэц хөгжсөн, илүү ашигтай байршилтай улс манайхаас хямд үнээр нийлүүлбэл бид өрсөлдөж чадахгүй. Тэгэхээр олборлох шатанд бид зайлшгүй сайжруулах шаардлагатай зүйл бол ТЭЗҮ буюу эдийн засгийн үр ашгийн тооцоолол. Уул уурхай Монгол Улсын хөгжилд урт хугацаанд хувь нэмрээ оруулж чадах уу, Монголын ард түмэн татвар хураамж хэлбэрээр, ажил эрхлэх хэлбэрээр үр ашгаас нь хуваалцаж чадах уу? гэдэг асуулт. Яам дангаараа энэ бүгдийг нягтлахгүй шүү дээ. Тогтолцоо, дэд бүтцийг нь л бий болгож өгнө. Олборлолтын дараах явц манайд янз бүр л байна. Коксжих нүүрс гэхэд зах зээл дээр маш өндөр үнэ хүрэхийг ч үзлээ, ёроолдоо хүртэл унахыг ч харлаа. Тэгэхээр олборлох уурхайнууд дээр бид маш няхуур хандах ёстой юм байна. ТЭЗҮ гэдэг чинь маш чухал зүйл байна. Бодитой дүгнэлт хийхгүй бол уурхайг нээж болно. Бас хаах ч хэрэг гарч болно. Тэнд байгаа байгаль орчин, сум суурин, хүмүүсийн ахуй амьдралд нөлөөлсөн зүйлүүд бүгд улсын нуруун дээр ирнэ. Тэгэхээр нөхөн сэргээх, хаалтын асуудал яаж яригдах юм. Зөвхөн уул уурхайгаасаа гадна түүнийг дагасан байгаль орчин, хүмүүсийн ахуйамьдралынасуудалдээрбусад яамтайгаа хамтраад оновчтой зөв бодлого гаргах ёстой. Амжилттай жишээнүүд дэлхийд олон байна, амжилтгүй жишээнүүд ч байна. Олборлоод гараад ирсний дараа эцсийн хэрэглэгч дээр очих ёстой. Хамгийн эхний асуудал дэд бүтэц. Тавантолгойн бүлэг орд дээр төмөр замын асуудлаа өнөөг хүртэл шийдвэрлээгүй, автозамаар тээвэрлэж байна. Төмөр замаар тээвэрлэснээс даруй 3-4 дахин өндөр үнээр тээвэрлэдэг. Дахиад өрсөлдөх чадварын тухай яригдана, илүү өндөр үнэтэй бүтээгдэхүүн болж очоод байна. Уул уурхай ярьж байгаа тохиолдолд дагалдах дэд бүтцийн асуудал зайлшгүй яригдана. Уул уурхайн түүхий эд ашигласан хүнд үйлдвэрийн тухай ярьж байгаа бол дэд бүтцийн асуудал илүү томоор хөндөгдөнө. Нөгөө эрчим хүчний асуудал, усны хэрэглээ яригдана. Гэх мэтчилэн цогц асуудал учраас хайгуул хийхээс эхлээд хамгийн эцсийн боловсруулсан бүтээгдэхүүн болгон гаргаж байгаа энэ бүх үе шатыг харж байгаа гэдгээрээ таны хэлсэн бодлогын уялдаа оновчтой гарах бололцоо бүрдсэн юм болов уу гэж харж байна.

> ...Дэлхийн 200 гаруй улсаас байгалийн баялагтай 50 гаруй улс байна. Энэ 50 улсын хаана нь бид яваа вэ гэдгээ байнга харах ёстой. Байгалийн баялаг өөрөө хязгаарлагдмал. Тэнд байгаа хэдэн тэрбум ам.долларыг энэ хэдэн улс л хувааж авах гээд байна шүү дээ. Арай илүү авахын тулд бид зөв, оновчтой төрийн бодлого, зохицуулалт, хууль тогтоомжтой байж, энэ 50 орны эхний 10-т байхаар хөгжих ёстой...

**-Хөрөнгө оруулагчид биднээс ямар нөхцлийг шаардаж байна?**

-Манай хууль тогтоомж хөрөнгө оруулалтыг татах чадвартай байна уу, үгүй юу гэдгээр л бид өрсөлдөнө. Хууль тогтоомж ойлгомжтой, олон янзаар тайлбарлагддаггүй, хэн ч уншсан нэг л янзаар уншигддаг байх ёстой. Хөрөнгө оруулагчид “би ингэж болно, ингэж болохгүй” гэдгээ ойлгож, ямар эрсдэл хүлээж байгаагаа тооцоолсон байх ёстой. Хоёрдугаарт, уул уурхайгаас хөрөнгө оруулалт татахыг чармайж байгаа дэлхийн бусад улс орнуудтай өөрсдийгөө харьцуулах хэрэгтэй. Зарим тохиолдолд уул уурхайдаа хөрөнгө оруулалт татаж байгаа мөртлөө тэр нь тухайн улсдаа хор хөнөөлтэй тийм бодлоготой улс байж болно шүү дээ. Бид түүний төлөө явж байгаа юм уу, эсвэл урт хугацаанд улсдаа ашигтай, хөрөнгө оруулагч нарт ч ашигтай байх бодлогын төлөө явж байна уу гэдгээ тодорхойлох ёстой. Хоёр тал тохирсон бол түүнийгээ мөрддөг байх ёстой. Тэр чадавхи нь манайд бас суугаагүй байна. Төр ч бай, хувийн хэвшил ч бай аль аль нь ашиг хүртэхийн төлөө гэрээ хэлцэлд ордог. Хэн хэн нь бусдаасаа давуу ашиг хүртэхийг сонирхож байгаа. Хэлэлцээрийн үр дүнд 50:50 хувийн ашигтай байж чадвал энэ хэлэлцээр шударга боллоо гэж үздэг. Ийм хэлцэл харьцангуй удаан хугацаанд хүчин төгөлдөр байх боломжтой. Аль нэг талд нь илүү ашигтай байх юм бол өөрсдөө ч үүнийг мэдээд дургүй байна. Гуравдагч талууд ч хөндлөнгөөс хараад дургүйцэх нь мэдээж.

**-Манай хууль тогтоомжийн хүрээнд тийм тэгш боломж олгож чадаж байгаа юм уу?**

-Хуульд бол ерөнхий зохицуулалт байгаа. Энэ хүрээнд гэрээ хэлцлээ оновчтой хийх ёстой. Хууль тогтоомж, аливаа бичиг баримт бол цаг үеэ дагаад өөрчлөгдөж байдаг. Технологио дагаад өөрчлөгдөнө. Уул уурхай бол нэг талаас технологийн салбар. Илүү бага зардлаар хайгуул хийдэг болох байх, магадгүй илүү өндөр зардлаар боловсруулдаг ч болох байх. Технологи өөрчлөгдөж байгаа үед хууль тогтоомж өөрчлөгдөж болно. Манайтай адил уул уурхай дагаж хөгжих, хөрөнгө оруулалт татах гэж чармайж байгаа цөөхөн улс байгаа шүү дээ. Дэлхийн 200 гаруй улсаас байгалийн баялагтай 50 гаруй улс байна. Энэ 50 улсын хаана нь бид яваа вэ гэдгээ байнга харах ёстой. Байгалийн баялаг өөрөө хязгаарлагдмал. Тэнд байгаа хэдэн тэрбум ам.долларыг энэ хэдэн улс л хувааж авах гээд байна шүү дээ. Арай илүү авахын тулд бид зөв, оновчтой төрийн бодлого, зохицуулалт, хууль тогтоомжтой байж, энэ 50 орны эхний 10-т байхаар хөгжих ёстой. Нүүрсний салбарт бид асар их сургамж авсан. Улс ч, компаниуд ч тэр. Нүүрс бол ихээр тээвэрлэдэг түүхий эд учраас хамгийн түрүүнд дэд бүтцээ шийдэх ёстой. Төмөр замаа шийдэж байж, Монголын нүүрс өрсөлдөхүйц бүтээгдэхүүн болно. Хятадын зах зээл дээр ч, түүнээс цааш ч тэр. Нүүрсний үнэ хямдрах тусам манай өрсөлдөх чадвар байхгүй болж байна. Тиймээс нүүрсний салбар, төмөр замын асуудлыг улс бодлогоор дэмжих ёстой. Өнөөдөр үнэ жаахан сэргэж байна. Ийм үед бид зайлшгүй дэд бүтцийн ажлаа яаралтай эхлүүлэх, дуусгах ёстой. Тэгж байж Тавантолгойн орд эдийн засгийн үр ашгаа олж авч чадна.

**-Дахиад л Зам тээврийн яамнаас хамаарсан шийдвэр гарах байх?**

-Бид энэ асуудлыг хамтраад ярьж байна, ахиц гарна гэж бодож байна. Шийдэл гарч таарна, бүтээн байгуулалтын ажил явна. Төр, хувийн хэвшил хамтарсан хувилбараараа хийгдэнэ. Тавантолгойн бүлэг ордоос экспортолж байгаа нүүрсийг Хятадын зах зээл дээр өрсөлдөхүйц байлгая гэвэл төмөр замын асуудлыг зайлшгүй шийдэх ёстой. Нэмүү өртөг шингээе гэвэл боловсруулах ёстой. Магадгүй гуравдагч зах зээл, Өмнөд Солонгос, Япон руу коксжих нүүрс экспортлох бололцоотой.

**-Шинэ Засгийн газар байгуулагдлаа. Гадны хөрөнгө оруулагчид, компаниуд Монгол Улсын төрийн залгамж халаа хэрхэн цааш үргэлжлэх бол. Монгол руу хөрөнгө оруулалт хийхэд хууль эрх зүйн орчин нь бидэнд ямар таатай нөхцлийг санал болгох бол гэж бодож байгаа. Уул уурхайн яам гадаад бодлогын хувьд ямар бодлого барьж байгаа вэ?**

-Сонгууль болж, нэг нам ялж Засгийн газар байгуулагдсан тухай мэдээлэл дэлхий нийтэд цацагдсан. Эхний мэдээллээр маш зөв мессэж очсон гэдэг нь гадны хөрөнгө оруулагчдын хандлагаас ажиглагдаж байна. Одоо биднээс эрхзүйн тогтвортой орчныг л хүсч байна. Үүнийг шинэ Засгийн газар удахгүй тодорхойлоод олон нийтэд зарлах ёстой юм. Одоо төлөвлөж байгаагаар шинэ Засгийн газар арваннэгдүгээр сарын сүүлээр энэ тогтвортой байдлыг ерөнхийдөө зарлах байх. Энэ бол маш том мессэж болно. Яагаад гэхээр эрдэс баялгийн түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр уначихсан байгаа. Энэ онд байж болох хамгийн доод хэмжээнд оччихлоо. Цаашдаа өсөх хандлага ажиглагдаж байна. Дунд ба урт хугацаандаа эрдэс баялгийн үнэ өснө. Ялангуяа манай гол түүхий эд зэсийн үнэ өсчих болов уу гэж би эдийн засагч хүний хувьд харж байна. Тэгэхээр энэ оны сүүл гэхэд тогтвортой байдлыг Засгийн газар зарласнаар гадны хөрөнгө оруулагчдад итгэл үүснэ. Зөвхөн Монгол эрдэс баялагтай биш Чили, Перу, Өмнөд Африк гээд эрдэс баялгаар баян орнууд байна. Бүгдээрээ хөрөнгө оруулалтын төлөө дайтаж байна. Монгол Улсад гадны хөрөнгө оруулалт ямар салбарт орж ирэх вэ гэдэг нь ойлгомжтой. Уул уурхайн салбарт л орж ирнэ. Өөр ямар ч салбарт одоогоор орж ирэхгүй. Уул уурхайн салбар бол яалт ч үгүй тэргүүлэх салбар. Яваандаа бид бусад салбарыг хөгжүүлэх тухай ярина уу гэхээс өнөөгийн нөхцөл байдалд уул уурхайн салбараас л хөрөнгө орж ирнэ. Монголын Засгийн газар тогтвортой байдлыг яаралтай зарлах тусам том мессэж болно. Дээрээс нь хайгуулын буюу уул уурхайн компаниудын сезон маш богинохон. Бүх шийдвэрүүдийг дараа жил юм уу, урт хугацааны хөрөнгө оруулалтын шийдвэрийг оны сүүл юм уу эхэнд гаргадаг. Дэлхийн бусад орнууд ч мөн адил. Бид амжиж зарлавал 2017 онд том компаниуд Монголд орж ирэх төлөвлөгөөгөө гаргана гэсэн үг. Хэрвээ бид 2017 оны дундуур ч юм уу, оройтож зарлавал оройтсон асуудал болно.

**-Хууль эрхзүйн орчин олон жилийн шат дамжлагаар улс орны хөгжлөө дагаад харьцангуй нааштай болсон гэж саяхөрөнгө оруулалтын чуулган дээр гадныхан дүгнэж байсан. Эрхзүйн орчин нарийн болох тусам зарим талаар сөрөг зүйл гарахыг үгүйсгэхгүй. Энэ гарах эрдслээс хамгаалах тал дээр манайх юу хийж байгаа вэ?**

-Хууль нарийн болно гэхээсээ илүү миний ажигласнаар манайх хуулиудаа сайн тайлбарладаггүй юм болов уу. Ялангуяа 2014 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийг гадны хөрөнгө оруулагчдадсурталчлантаниулах, ямар давуу тал үүсч байгааг тайлбарлах тал дээр хангалтгүй зүйл бий. Хууль нарийн болсноор эрсдэл үүсэх магадлал бага гэж ойлгож байна.

**-Монголд ажиллаж байгаа “Эрдэнэ ресурсес дэлхийд тавд орох зэсийн нөөцтэй орд, Гацууртын ордны нөөцөөс гурав дахин том алтны орд нээсэн гэсэн. Гэвч уурхай зарим асуудлаас болж хүлээгдэж байгаа гэсэн. Яагаад…?**

-“Эрдэнэ ресурсес”ын хүлээж байгаа байдал өмнөх Засгийн газраас л үүдэлтэй. Шинэ Засгийн газар тогтвортой байдлаар зарлан, нээлттэй тогтвортой бодлого явуулах юм бол бүх ажил ахицтай болох байх гэж бодож байна.

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# Приус осолдож, МОНГОЛЧУУД АМИА АЛДСААР Л...

Цагдаагийн газраас авч байгаа өнгөрсөн хоногуудын гэмт хэргийн мэдээг уншихад автомашины осол багагүй хувийг нь эзэлдэг. Тэр дунд өдөртөө хэд хэдэн ноцтой гэж болохоор осол ёс юм шиг гарч байгааг ч уншиж болно. Тэгэхдээ приус машинтай явж байсан нөхдүүд хурд хэтрүүлэх, дүрэм зөрчих зэргээс үүдэн осолд өртөхдөө ихэнх нь амиа алдаж байгааг ч тоон мэдээлэл харуулж байгаа юм. Тиймээс "Монголын мэдээ" сонин энэ удаагийн "Онцлох хуудас" булангаараа приус машинтай явж байгаад осолд орж, амиа алдсан тохиолдлуудыг онцолж байна.

### ПРИУС ОНХОЛДОЖ, 22 НАСТАЙ ЭРЭГТЭЙ НАС БАРЛАА

**2016.09.17:** Ердөө л дөрөвхөн хоногийн өмнө гарсан осол. Энэ талаар цахим хуудсууд мөн мэдээлсэн. Тодруулбал "Замын цагдаагийн газарт нийт 270 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 213 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 12 бүртгэгдэж, хоёр хүний амь нас хохирч 14 хүн хүнд, хөнгөн гэмтсэн. Зам тээврийн осолд сургуулийн насны гурван хүүхэд өртсөн байна. Харин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 39 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэргээс урьдчилан сэргийлж ажилласан байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн нутаг Баруун салааны зам, Тэс петролиум ШТС-ын урд замд Prius маркийн Н жолоочтой авто машин онхолдож жолооч 22 настай эрэгтэй Н-ийн амь нас хохирч зорчигч 22 настай эрэгтэй Л гэмтжээ" хэмээн мэдээлсэн юм.

### ПРИУС МАШИН ОСОЛДОЖ, ГУРВАН ХҮН АМИА АЛДЖЭЭ

**2016.02.15:** Цагаан сарын үеэр цагдаагийн газраас гаргасан хоногийн мэдээнд энэ талаар дурдсан. "Замын цагдаагийн газар өнгөрсөн баярын өдрүүдэд түргэн шуурхай ажиллаж байсан талаар бид өмнө нь мэдээлсэн. Тэгвэл орон нутагт зам тээврийн ослоор өнгөрсөн амралтын өдөр гурван хүн амиа алджээ. Тухайлбал, Булган аймгийн Бугат сумын нутаг Зоон даваа гэх газарт энэ сарын 13-нд Тоёота Приус маркийн машин зам тээврийн осол гаргаж 21 настай эрэгтэй Ц, 21 настай эмэгтэй Б нар нь амиа алджээ. Мөн Ховд аймгийн Мөст сумын нутаг Бургасны хөндий гэх газар Ниссан Санни, Тоёота Приус маркийн автомашинууд мөргөлдөж, 78 настай эрэгтэй Т гэгч амиа алдсан байна" хэмээн мэдээлсэн.



### ПРИУС МАШИН ОНХОЛДОЖ, НЭГ ХҮН НАС БАРЛАА

**2016.09.16:** Энэ сарын 15-нд дахиад л осол гарав. Энэ талааар цахим хуудсууд "Өнгөрсөн өдөр хөдөө орон нутгийн замд хоёр осол гарч, хоёр хүн нас баржээ. Тодруулбал, Сүхбаатар аймгийн Мөнх сумын төвөөс хойш 60 км-т Цагаан усны хоолой гэх асфальтан замд Т.Prius маркийн Б жолоочтой авто машин онхолджээ. Улмаар жолооч 31 настай эрэгтэй Б-ийн амь нас хохирсон байна. Мөн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 дугаар багийн нутаг Домбрын уулзварт Н.Grace маркийн авто машины жолооч С нь явган зорчигч долоон настай эмэгтэй А-г мөргөж амийг нь хохироожээ" хэмээн мэдээлсэн.

### ПРИУС МӨРГӨЛДӨЖ, ДОЛООН ХҮН АМИА АЛДЛАА

**2016.08.09:** Өнгөрсөн наймдугаар сард гарсан мэдээлэл. Бас л цагдаагийн газраас өгсөн. Тодруулбал, "Наймдугаар сарын 5-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын Хөшөөт багийн нутаг дэвсгэрт зам тээврийн ноцтой осол гарч дөрвөн том хүн, гурван хүүхэд амь насаа алджээ. Тодруулбал, Тоёота Приус маркийн автомашин Тоёота Ланд Круизер маркийн автомашинтай мөргөлдөж, Тоёота Приус маркийн авто машинд зорчиж явсан дөрвөн том хүн, гурван хүүхэд амиа алдсан байна. Т.Landcruicer маркийн авто машинд зорчиж явсан гурван хүн гэмтжээ. Осол оройн 20:00 цагийн үед гарсан бөгөөд Т.Prius маркийн автомашин нь Архангай аймгаас Улаанбаатар хотыг чиглэж явсан бол Т.Landcruiser маркийн автомашин Улаанбаатар хотоос Өвөрхангай аймаг руу явж байжээ" хэмээн мэдээлсэн юм.

### ПРИУС МӨРГӨЛДӨЖ, НЭГ ХҮН НАС БАРЖ, ДӨРВӨН ХҮН ГЭМТЛЭЭ

**2016.09.14:** Энэ сард гэхэд худал хэлсэн хүнд өдөр болгон приус машин осолдож, хүний амь нас хохирсон. Тухайлбал, наймдугаар сарын 13-ны өдөр гарсан осол. Энэ талаар цагдаагийн байгууллагаас "Зам тээврийн ослын улмаас өчигдөр хоёр хүн амиа алдсан байна. Тухайлбал, Хонхорын замд Н.Accent, Т.Prius машин мөргөлдөж 26 настай эрэгтэй амиа алдаж, дөрвөн хүн гэмтжээ. Мөн өчигдөр Архангай аймгийн Өндөр Улаан сум, Донгой багийн төвөөс зүүн зүгт Istana маркийн машин, Мустанг-5 мотоциклтой мөргөлдсөний улмаас 37 настай эрэгтэй амиа алдаж, нэг хүн гэмтсэн байна" хэмээн мэдээлсэн юм.

Сэтгүүлчийн өнцөг

# АМИНААС ҮНЭТЭЙ ХЭМНЭЛТ ГЭЖ БАЙХ УУ

Н.ПУНЦАГБОЛД

Монголчууд бид хэмнэлт хийх гэж, шатахуун бага зарцуулдаг машин худалдаж авах сонирхолтой болсон. Нөгөө талаар тийм хэрэгцээ шаардлага байгаа ч гэж зүтгэж болох юм. Харин энэ шаардлагыг приус машин хангаж байгаа гэдэгт ойлгочихоц болох байх. Приус 10, 11, 20, 30, цаашлаад 50 гээд янз янзаар нь үйлдвэрлэж байна, японччууд. Энэ машин шидтэй юу шидтэй, давуу тал ихтэй юу гэвэл тийм. Муу хэлэх юм байхгүй ээ. Шид нь шатахуун үнэхээр бага зарцуулдаг. Өнөөдөр Улаанбаатар хотод түгжрээд машинтай явах нь битгий хэл явган алхахад хэцүү болсон цаг. Ийм нөхцөлд приус шиг сайхан унаа хаана байна. Өвөл ч гэсэн шатахууныг үнэрлээд байгаа. Дээрээс нь өнгө үзэмж сайтай, тохилог. Багтаамжаар ч муу биш.

Гэх мэтээр сайн сайхан зүйл алийг тэр гэхэв. Ганцхан энэ машин үнэхээр хэврэгхэн. Шар айрагны лааз шиг нимгэн төмөртэй гээд хэлчихэд нэг их холо зөрөхгүй болов уу. Үүнээс үүдээд багахан осол гарахад л жолооч нь, зорчигч нь ноцтой бэртэж, амь насаа алдах дээрээ тулчихаад байна. Осолдлоо, мөргөлдлөө гэхэд гишгэсэн лааз шиг болчихоор яаж тэндээс хүн амьд гарах вэ дээ. Гэтэл манайхан ийм машиныг л унаж хөдөө орон нутгийн замд хурд хэтрүүлэн давхиж байгаа. Улаанбаатар хотод ч гэсэн хурд хэтрүүлж, дүрмээ биелүүлэхгүй дайрснаас болоод осолд ордог, амиа алддаг. Уншигч та дээр дурдсан хэдхэн жишээг харж байгаа байх. Энэ бол приустэй явж байгаад осолд орж, амиа алдсан хүмүүсийн ердөө л хэлтэрхий нь. Яг ийм осол, гэмтэл, амиа алдсан жишээг өдөр өдрөөр нь жагсааж бичсэн ч бараг болно. Ийм л байна. Зарим хүмүүс толгойтой болгон приус унаж байхад гарч байгаа осол нь олон байхгүй яах вэ дээ гэж хэлж магадгүй. Тэгвэл нэг тоо баримт дурдья. Монгол Улсад 600 гаруй мянган тээврийн хэрэгсэл байгаа. Түүний ердөө л 10 гаруйхан хувь нь буюу 60-70 мянга нь приус гэсэн тоо баримт байна.

Тийм ч замбараагаа алдчихсан тоо бас биш. Гэтэл яагаад осол гарах болгонд заавал приус унаж явсан хүмүүс нь амиа алдаад байна вэ гэдгийг л бодолцох цаг болж. Бид хэмнэж, шатахуун бага зарцуулдаг машин унах л хэрэгтэй байх. Гэхдээ амь нас, эрүүл мэндээ хамгаалах нь хэмнэлтээс илүү л байлтай. Ядаж л приус унаж байгаа бол хурдаа зөв тохируулж яваач ээ, хүмүүс минь. Приустэй орон нутгийн замд том машинтай хурдтай зөрөхөд хийсээд уначихсан тохиолдол ч гарсан. Ер нь бол эрх баригчид зоригтойхон шийдээд, приусны татварыг нэмчих л хэрэгтэй. Зөрүүлээд арай дөнгүүр, аятайхан машины татварыг жаахан бууруулчих л даа. Өнөөдөр бүхий л машин хосолмол хөдөлгүүртэй болчихсон шүү дээ. Бид өөрсдийгөө, төр засаг нь ард иргэдээ бодохгүй бол гуравхан сая монголчууд өдөрт хэд хэдээрээ осолд орж амиа алдсаар дуусах нь байна.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ДЭЛХИЙ

## Пакистаны сүмд дэлбэрэлт болж, 36 хүн нас барлаа

Пакистаны баруун хойд этгээдийн бүс нутаг дахь нэгэн сүмд дэлбэрэлт болж, 36 хүн нас баржээ. Хохирогчдын найм нь хүүхэд байсан тухай орон нутгийн эх сурвалж онцолсон байна. Дэлбэрэлт Афганистантай хиллэн орших Мохманд гэх Засгийн газрын армийн лалын хэт даврагч "Пакистаны Талибан" бүлэглэлээс чөлөөлөх дайралт үргэлжилж буй бүс нутагт болжээ. Хэрэг гарах үед сүмд иргэд олноороо мөргөл хийж байсан аж. Улмаар арын эгнээнд хүүхдүүд мөргөл хийж байсан бөгөөд амиа золиослогч этгээд өөрийгөө дэлбэлснээр олон хүн амь үрэгджээ. Харин дэлбэрэлтийг Талибаны "JuA" гэх бүлэглэл үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийг хийсэн аж. Тэд 2009 онд орон нутгийн арми тус бүлэглэлийн 13 дайчныг хөнөөж, мөн төчнөөн тооны хүнийг баривчилсны хариу цохилт гэж тайлбарласан байна. Түүнчлэн, энэ явдалтай холбоотойгоор Мохмандад хөл хорио тогтоож, шөнийн цагаар гадагш гарахыг хоригложээ.

## Тайландад мөргөлчдийн завь осолджээ

Тайландын Чао Фрая голд лалын шашинт мөргөлчдийг тээвэрлэж явсан завь гүүр мөргөн осолдож, 15 хүн нас барж, 11 хүн ор сураггүй болсонд тооцогдож байгаа аж. Энэ талаар эрх баригчид нь өчигдөр мэдээлсэн байна. Осол аялал жуулчлалаараа алдартай эртний Аюттая хотын ойролцоо болжээ. Гэхдээ ослоор нас барагсдын дотор гадаадын жуулчин байгаагүй гэнэ. Тухайн үед хөлөгт 100 орчим хүн зорчиж явжээ. ее Бангкок хотоос хойш 80 км-т байрлах тус хотын гамшгаас хамгаалах албаны эх сурвалж "франц пресс" агентлагт өгсөн ярилцлагадаа 30 гаруй хүн гэмтэж бэртсэн талаар дурьджээ. Завь голд хөвж явсан бусад хөлгөөс зайлах гэж байгаад бетонон гүүр мөрдөж, сүйрсэн байна. Зорчигчид бүгд орон нутгийн иргэд байжээ. Мөн тэдний ихэнх нь лалын шашны мөргөлчид байсан бөгөөд ойролцоох сүмд мөргөл үйлдээд буцах замдаа ийнхүү осолдсон байгаа юм.



## ОРОСЫН ЭРХ БАРИГЧ НАМ ҮНЭМЛЭХҮЙ ОЛОНХИ БОЛЛОО

Б.ДАВААХҮҮ

ОХУ Крымын хойгийн зарим хэсгийг өөртөө нэгтгэснээс хойшхи анхны төрийн думын сонгуульд эрх баригч нам үнэмлэхүй олонхи болжээ. Сонгуулийн санал хураалт албан ёсоор дууссаны дараа гарцан дахь санал хураалтын дүнгээр эрх баригч нам нэгэнт ялах нь тодорхой болсон байна.

Улмаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин болон эрх баригч "Нэгдсэн Орос" намын дарга Дмитрий Медведев нар ялалтаа зарлаж, "Бид үнэмлэхүй олонхийн суудал авлаа" хэмээжээ. Сонгогчид ирэх таван жилд хууль тогтоох Төрийн думын 450 гишүүнийг сонгох бөгөөд тэдний 225-ыг шууд үлдсэнийг нь намын жагсаалтаар сонгосон юм. Эдийн засгийн өсөлт саарч буй тус улсад В.Путины дэглэмийг дэмжигч "Нэгдсэн орос" нам олонхи болох эсэх нь олон улсын анхаарлыг татаж байв. Сонгуульд нийт 14 нам өрсөлдөж байгаагаас хоёр нь Кремлийг эсэргүүцэгч нам аж. Эдгээр нам нь 136 тойрогт өрсөлдөж байгаа бөгөөд Оросын алслагдмал мужууд болон гадаадад байгаа иргэдийн саналыг эрт хураан авсан юм. Тэгвэл саналын хуудсын 90 хувийг тоолж дууссаны дараа Нэгдсэн Орос нам 54 хувийн санал авч, ялах нь нэгэнт тодорхой болсон бол Либериал Ардчилсан нам, Коммунист нам 13 хувийн санал авчээ. Харин дөрөвт эрэмбэлэгдсэн "Шударга Орос" нам 6.19 хувийн дэмжлэг хүлээжээ. Бусад намын хувьд таван хувь ч хүрэхгүй санал авсан байгаа юм. Тодруулбал, "Коммунист Орос" нам 2.36 хувь, Яблоко 1.69, Родина 1.40, Зеленые 0.71, Парнас 0.66, Патриоты России 0.57 хувийн саналыг тус тус авчээ. Нэгдсэн Орос нам нэг мандаттай 206 тойргийн 203-т нь ялалт байгуулсан үзүүлэлттэй явна. Крымын хойгийг өөртөө нэгтгэснээс хойш ОХУ-тай хурцадмал харилцаатай байх болсон Украинд тус улсын Төрийн Думын сонгуулийг эсэргүүцсэн хөдөлгөөн сонгуулийн үеэр өрнөөд амжжээ. Тэд ОХУ-ын сонгуулийн санал хураалтыг Украинд явуулахгүй, түүгээр ч зогсохгүй Оросын элчин сайдын яам болон консулын газарт санал хураалт явуулахыг зөвшөөрөхгүй гэж мэдэгдсэнийг барууны зарим хэвлэлд мэдээлж байсан юм. Гэхдээ ОХУ-ын тал олон улсын гэрээг зөрчиж байгааг сануулснаар санал хураалт явагджээ. Улмаар Украин дахь ОХУ-ын Элчин сайдын яам болон гурван консулын газарт Төрийн Думын сонгуулийн санал хураалтыг зохион байгуулсан хэдий ч, үүнийг эсэргүүцсэн украинчууд барилгын орох хаалгыг хаан зогсох зэргээр эмх замбараагүй байдал үүсгээд амжсан байна. Оросын сонгуулийн хорооны мэдээллээр Украинд Оросын 80 гаруй мянган иргэн амьдардаг ажээ. Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын 400 орчим ажиглагч Оросын Төрийн думын сонгуулийг ажиглажээ. Оросын Засгийн газар парламентын сонгуулийг зохион байгуулахад 11 тэрбум рубль буюу 170 сая америк долларыг хуваарилсан байна. Оросын төрийн думын өмнөх 2011 оны сонгуулиар будлиан гарч, улмаар Москвад олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөхөд хүргэж байсан аж.

Тухайн үед ОХУ-ын одоогийн эрх баригч Нэгдсэн Орос нам 49.32 хувийн саналаар ялалт байгуулж, төрийн думын нийт суудлын 53 хувь буюу 238 суудал авч байсан юм. Ямартай ч, энэ удаагийн сонгуульд Нэгдсэн орос нам үнэмлэхүй олонхи болсноор 2018 оны Ерөнхийлөгчийн сонгуульд В.Путин дөрөв дэх удаагаа улиран сонгогдоход томоохон түлхэц болж буйг зарим эх сурвалж онцолж байв.

## Паралимпад Хятад багаараа тэргүүллээ

Бразилын Рио де Жанейро хотноо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 15 дахь удаагийн паралимпийн наадам зохион байгуулагдаж, ням гарагт хаалтаа хийлээ. Наадам энэ сарын 7-нд эхэлж, 11 хоног үргэлжлэн хаалтаа хийсэн юм. Энэ удаагийн наадамд 159 улсын 4342 тамирчин спортын 22 төрлөөр 528 багц медалийн төлөө өрсөлдлөө. Хөлгүй ч хөлтэй хүнээс дутахааргүй гүйж, гаргүй хэрнээ усанд шумбаж, хараагүй хэрнээ хараатай юм шиг барилдаж, спортын олон төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэд медалийн төлөө өрсөлдөж, дэлхий нийт тэднээр бахархан 11 өдрийг үдлээ. Улмаар эцсийн дүнгээр Рио-2016 паралимпийн наадамд Хятад улсын шигшээ баг нийтдээ 239 медаль авснаар багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн юм. Тус улсын баг 107 алт, 81 мөнгө, 51 хүрэл медаль хүртжээ. Ингэснээр тэд өмнөх Паралимпод үзүүлсэн дээд амжилтаа шинэчилж чадлаа. Тодруулбал, 2012 оны Лондонгийн Паралимпын тоглолтод Хятадын тамирчид 231 медаль /95-71-65/ хүртэж байв. Багийн дүнгээр, хоёрдугаар байрт 64 алт, 39 мөнгө, 44 хүрэл, нийт 147 медаль хүртээд буй Их Британийн баг тамирчид орж байна. Гуравдугаарт нийт 117 медальтай /41-37-39/ Украин улсын баг, дөрөвдүгээрт 115 медаль /40-44-31/ хүртсэн АНУ-ын тамирчид, айргийн тавд 79 медаль /22-30-29/ хүртсэн Австралийн шигшээ баг тус тус бичигдэж байна. Дашрамд дурдахад, Паралимпын түүхэнд хамгийн олон алтан медаль хүртсэн баг бол АНУ-ын баг юм. Нью-Йорк болон Их Британийн Сток-Мандевиль хотуудад 1984 онд болсон Паралимпын тоглолтоос америкчууд 137 алтан медаль, нийтдээ 397 медаль /137-131-129/ хүртэж онцгой амжилт үзүүлж байжээ.




ХААН БАНК

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянаж мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 5000045060000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг procurement2016@khanbank.com хаягт хандаж авна уу.

Харилцагчийн мэдээллийн төв 1800-1917 | www.khanbank.com | khanbank.com/facebook | khanbank.com/twitter

# ШУУРХАЙ МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## НОЙТОН ЦАС ОРЖ, СЭРҮҮСНЭ

Энэ сарын 20-24-нд баруун аймгуудын зүүн хэсгээр бороо орж, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй байгаа аж. Харин төвийн аймгуудын нутгаар өнөөдөр бороо орж, 23-24-нд ихэнх нутгаар, 25-ны өдөр нутгийн зүүн хэсгээр бороо орж, уулархаг нутгаар нойтон цас орох юм байна. Мөн зүүн аймгуудын нутгаар энэ сарын 20-21-нд зарим газраар бага зэргийн бороо, 23-нд нутгийн баруун хэсгээр, 24-25-ны өдөр зарим газраар бороо, Хэнтийн уулархаг нутгаар нойтон цас орно. Говийн аймгуудын нутгаар 21-22 болон 25-нд нутгийн хойд болон зүүн хэсгээр бороо орно. Салхи 23-25-нд зарим газраар 16м/с хүрч шороогоор шуурах юм байна. Тиймээс иргэд, малчид, тариаланчдад анхаарал болгоомжтой байхыг Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс анхаарууллаа.

## “Эерэг хандлага - эрүүл оюутан” аяныг зарлалаа

О.ТӨРТОГТОХ

Эрүүл мэндийн сайдын 309 дүгээр тушаалаар жил бүрийн есдүгээр сарыг “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар” болгон тэмдэглэдэг уламжлалтай болсон билээ. Тэгвэл энэхүү өдөрлөгийг энэ жил “Эерэг хандлага - Эрүүл оюутан” уриан дор тэмдэглэхээр болсон тухай ДЭМБ, ЭМЯ-ны төлөөлөгч нар өчигдөр “Үндэсний мэдээллийн төвд” мэдээлэл хийлээ. Тус аяныг НҮБ-ын Хүн амын сан, ДЭМБ, ЭМЯ, НЭМХ, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тус тус хамтран зохион байгуулж байгаа аж. Мэдээллийн үеэр эмя-ны НЭМХ-ийн мэргэжилтэн Б.Болорчимэг “2015-2016 оны хичээлийн жилд 181 их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д нийт 205 301 оюутан суралцсан тоон үзүүлэлт бий. Суралцагчдын 46 хувийг эрэгтэй, 54 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Иймд тус аяны хүрээнд нөхөн үржихүйн эрүүл мэнд, хоол хүнсний буруу хэрэглээ, хорт зуршлаас эрүүл мэндээ хамгаалъя, БЗДХ, ХДХВ/ДОХ-аас сэргийлье, жирэмсний хяналт зэрэг сэдвээр 5000 орчим оюутныг хамруулж, лекц сургалт явуулна.

Түүнчлэн энэхүү өдөрлөгт нэг болон хоёрдугаар курсын оюутнуудыг илүүтэй хамруулах гэж байгаа. Учир нь эцэг эх, асран хамгаалагчийн хараа хяналтаас холдож, бие даан амьдрах эхний жилдээ тэд өөрийн эрүүл мэндийг хамгаалах мэдлэг, чадвар дутмагаас үүдэн хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвар, архи тамхи, мансууруулах бодисын хэрэглээ зэрэг олон эрсдэлд өртөх магадлал өндөр болдог. Тухайлбал, өнгөрсөн жил нийт 80 434 эх амаржсаны 50.5 хувийг 20 хүртэлх насны эхчүүд эзэлж байсан бол үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдийн 5.1 хувийг 20-иос доош, 70 хувийг 20-34 насныхан эзэлж байгаа талаар тоон судалгаа гарсан байдаг. Үүнийг өмнөх оныхтой харьцуулахад 20-иос доошхи насны эмэгтэйчүүдийн үр хөндөлт 15 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа” хэмээсэн юм. Дашрамд дурьдахад, дээрх аяны хүрээнд олон өдөрлөг зохиогдох бөгөөд залуусын сонсох дуртай хамлаг, дуучид ч мөн ая дуугаа өргөх юм байна.

# Н.ЭРДЭНЭЖАВ: УЛС, ХОТ ХООРОНДЫН ТЭЭВРИЙН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ЭХЛҮҮЛСЭН



Н.БАТЗАЯА

*Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Хөдөлгөөний хяналтын хэлтсийн дарга Н.Эрдэнэжаваас өвөлжилтийн бэлтгэлийн талаар зарим зүйлийг тодруууллаа.*

**-“Хөдөлгөөний удирдлага, хяналтын төв” яг ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?**

-Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэн автотээврийн хөдөлгөөнийг улсын хэмжээнд хянах төв байгуулах” ажлын хүрээнд “Хөдөлгөөний удирдлага, хяналтын төв” 2014 оны нэгдүгээр сард байгуулагдсан. Энэхүү төвийг манай хэлтэс хариуцан ажиллуулдаг. Мөн энэхүү төв дээрээ түшиглэж “1900-1234 Автотээврийн нэгдсэн лавлах”-ыг 2015 оны хоёрдугаар сараас ажиллуулж эхлээд байна.

**-Хөдөлгөөний хяналтын хэлтэс Улс хооронд болон хөдөө орон нутгийн зам дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянадаг гэдгийг иргэд мэднэ. Тэгэхээр үйл ажиллагааныхаа чиглэлийн талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Улс хооронд, орон нутгийн зорчигч тээврийн зохицуулалтыг 24 цагийн турш хийж ажилладаг. Ажиллагааны зарчим нь тээврийн хэрэгсэлд суурилуулсан байршил тогтоох төхөөрөмжийн мэдээллийг GSM/GPRS болон сансарын холбоо /Inmarsat/ ашиглан дамжуулж төв серверт хадгалах ба интернэтийн орчинд ажиллаж байгаа компьютер, таблет, ухаалаг гар утас ашиглан зориулалтын програм хангамжаар тээврийн хэрэгслүүдээ хянах боломжтой, дэвшилтэд технологид суурилсан цогц систем юм. Тухайлбал, тухайн зорчигч тээврийн хэрэгсэл яг хаана явж байна, батлагдсан замналын дагуу цагийн хувиараараа явж байгаа эсэх талаар хяналт тавьж, цаг агаарын таагүй нөхцөл, эвдрэл гэмтэл, ослоос хамаарч саатвал мэдээллийг шуурхай дамжуулах, зорчигчдыг хэрхэн шилжүүлэх талаар зохицуулалт хийж ажилладаг. Бид ОБЕГ, ЗЦГ, УЦУОСМХ, аймгуудын Автотээврийн төвүүд, орон нутгийн АЗЗА-ууд, Орон нутгийн постууд, зорчигч тээвэрлэх эрх бүхий ААН-үүд, жолооч нартай шууд холбогдон хамтран ажилладаг. Иргэн та ч гэсэн Улс, хот хооронд, орон нутгийн зорчигч тээвэртэй холбоотой гомдол, санал ирүүлэх, зорчигч тээврийн хэрэгслүүд яг хаана явж байгаа, хэзээ Зорчигч үйлчилгээний төвүүдэд ирэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг 24 цагийн ажиллагаатай 70070012 утаснаас авч болно.

**-Технологийн дэвшлийг зорчигч тээврийн үйлчилгээнд хэрэглэж байна гэсэн үг үү?**

-Мэдээллийн технологийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх, ялангуяа Автотээврийн салбарт нэгдсэн бодлогоор, харилцан уялдаа бүхий цогц системийг нэвтрүүлэх зайлшгүй нөхцөл, шаардлага бүрдээд байна. Энэ талаар судалгаа, шинжилгээ хийж ажиллаж байгаа. Манай хувьд бол зорчигч тээвэрлэх эрх бүхий ААН-үүдийн тээврийн хэрэгслүүд бүрт байршил тогтоох GPS төхөөрөмж суурилуулж тухайн тээврийн хэрэгслийн байршил, хурд, хөдөлгүүрийн төлөв, зорчиж буй хөдөлгөөний чиглэл, ослын дохио, жолоочийн мэдээллийг цаг тухай бүрт нь хүлээн авч ажилладаг. Мөн нэмэлт мэдрэгч, төхөөрөмж суулгаснаар жолоочтой шууд холбогдох, текст мэдээлэл солилцох, тээврийн хэрэгслийн дотор гадна талыг камераар харах, зорчигчдыг тоолох, шатахуун зарцуулалт, ачааны жин болон дугуйн хийн даралтыг хэмжих, температурыг мэдээлэх, электрон лац зэрэг мэдээллийг дамжуулах боломжтой.

**-Танай төв тухайн тээврийн хэрэгсэлд ямар нэгэн асуудал тулгарахад хамгийн түрүүнд мэддэг гэж ойлгож болох уу?**

-Өнөөдрийн байдлаар Хөдөлгөөний удирдлага, Хяналтын төвд холбогдсон зорчигч тээврийн 1000 гаруй тээврийн хэрэгслийг бүрэн хянаж, тээвэр зохицуулалтыг хийж ажиллаж байна. Үүнээс улс, хот хоорондын зорчигч тээврийн том оврийн 355 автобус, дунд оврийн 195 автобус, суудлын /Такси/ 265 автобус, Ази, Европын бүсийн уулзалтанд АСЕМ-ын үед холбогдсон том оврын шинэ автобус 43, Аюултай ачаа тээвэрлэгч 14 тээврийн хэрэгслүүд тус тус манай системд холбогдсон байна.

**-Улс, хот хоорондын нийтийн тээвэрт GPS суурилуулснаар өөрчлөлт гарсан байх. Ихэвчлэн ямар саатал, гэмтэл гарч байна вэ?**

-Мэдээж өөрчлөлт гаралгүй яахав. Өдөрт дунджаар 320 -350 гаруй тээврийн хэрэгслээр 5-6 мянган зорчигчийг тээвэрлэдэг. Яг “Оюутан тээвэр”-ийн үед өдөртөө 10-12 мянган зорчигч тээвэрлэдэг. Энэ бүх статистик мэдээллийг тоон хэлбэрт оруулснаар ирээдүйд тээврийн бодлого яаж зохицуулалт хийх бэлэн өгөгдлийн сантай болж байна. Ихэвчлэн техникийн гэмтлээс үүдэлтэй саатлууд үүсдэг. Мөн цаг, агаарын онцгой үзэгдлээс хамаарч даваа, гүвээ хаагдах зэрэг болно. Байршил тогтоох төхөөрөмж ашиглаж 24 цагийн хяналт, зохицуулалттай болсноор ослын үзүүлэлт буурсан. Бид хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан, цаг агаарын болон гэнэтийн осол, саатлын үед тээврийн хэрэгслийн байршлыг түргэн шуурхай тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

**-Хөдөө орон нутгийн замд их осол гардаг шүү дээ. Энэ юутай холбоотой юм бэ?**

-Хурд хэтрүүлэх, бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох, замын нөхцөл байдлыг буруу тооцоолох гэх мэт хүчин зүйлүүдээс хамаарч хот хооронд, орон нутгийн автозамууд дээр осол их гардаг. Ялангуяа орон нутгийн замд хурд хэтрүүлэх нь их ажиглагддаг ба уг зам нь хурдны зам биш тул хурд хэтрүүлэлт нь хамгийн их осол болох шалтгаан нь болдог. Манай зорчигч тээврийн хэрэгслүүд 100 хувь хяналтын системд GPS төхөөрөмжөөр холбогдсон тул осол илт буурсан. Харин хулгайн тээврээр зорчиж яваад иргэд ололд их өртөж байгаад сэтгэл эмзэглэдэг. Энэ дашрамд “Иргэд та бүхэн минь техникийн хяналтын үзлэгт улирал бүр ордог тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал нь хангагдсан, даатгалтай, хяналттай, зөвшөөрөгдсөн зорчигч тээврийн хэрэгслүүдийг сонгон үйлчлүүлж байгаараа” гэж уриалж байна.

**-“1900-1234 Автотээврийн нэгдсэн лавлах” үйлчилгээний талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Энэ оны хоёрдугаар сарын 1-ээс үйл ажиллагаа нь эхэлсэн. Тус лавлах нь өдөр бүр 07. 00 – 22.00 цагийн хооронд Автотээвэртэй холбоотой бүхий л асуултанд хариулт өгч ажилладаг лавлах юм. Түгээмэл асуултууд гэвэл шилжилт хөдөлгөөн, импортын бүртгэл, архив лавлагаа, онлайн билет захиалга, тээврийн хэрэгслийн татвар, автомашин хааж тавьсан талаарх гомдол ирдэг. Тухайлбал “Автомашин хааж тавьсан тул жолоочтой нь холбож өгнө үү” гэсэн хүсэлт нийт дуудлагын 50 хувийг эзэлж байгаа нь үнэхээр анхаарал татахуйц харагдаж байна. Өнөөдөр нийслэл хотод маань автозогсоолын хүрэлцээ муу, орон сууц, албан байгууллагуудын гадна төлөвлөлт буруу хийгдсэн гэдэгтэй санал нийлнэ биз. Иймд авто зогсоол, хотын автозамын бөглөрлийг сааруулах талаар судалгаа хийж байгаа.

**-Удахгүй цас орно гэсэн мэдээллийг ус цаг уур, орчны судалгааны хүрээлэнгээс өгч байгаа. Улс, хот хоорондын нийтийн тээврийн өвөлжилтийн бэлтгэл ажил эхэлсэн үү?**

-Цаг үеийн холбогдолтой, оновчтой асуулт байна. Хөхүүрийн ам холдож, хүйтний ам хаянд ирсэн тул АТҮТ ТӨҮГ нь улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслүүдийн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах үе шаттай ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал, улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслийн техник үйлчилгээг энэ оны есдүгээр сарын 10-аас ирэх сарын 10-н хүртэл хийнэ. Нийтийн тээврийн том, дунд оврын хэрэгслүүдийг энэ оны есдүгээр сарын 10-аас ирэх сарын 10-ны хооронд техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулна. Мөн өвлийн улиралд нийтийн тээврийн хэрэгслийн дагалдах хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулах ажил эхэлсэн. Түүнчлэн Улаанбаатар хотыг тойрсон таван хяналтын постод Техникийн түргэн тусламжийн, тоноглогдсон тээврийн хэрэгслүүдийг аравдугаар сарын 10- аас эхлэх бүрэн байршуулахаар боллоо. Хэрэв нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд техникийн эвдрэл, гэмтэл, замын нөхцөл, ослоос хамааран саатал гарвал шуурхай арга хэмжээ авах зорилт бүхий тоноглогдсон, шатахуунаар цэнэглэгдсэн тээврийн хэрэгсэл 24 цагийн турш бэлэн байна гэсэн үг. “Өвөлд бид бэлэн” өдөрлөгийг аравдугаар сарын 15-нд зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдсан. Иргэддээ анхааруулахад техникийн хяналтын үзлэгт улирал бүр ордог тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал нь хангагдсан, даатгалтай, хяналттай, зөвшөөрөгдсөн зорчигч тээврийн хэрэгслүүдийг сонгон үйлчлүүлж байгаараа.

## Зуслангийн нийтийн тээврийн үйлчилгээг зогсоов

Нийслэлийн Тээврийн газраас зуны улирал эхэлж, зуслан чиглэлийн зорчих урсгал нэмэгдсэнтэй холбогдуулан ЗҮ:1 Гүнт-Жигжид-Тэнгис кино театр, ЗҮ:2 Гоодой-Тэнгис кинотеатр, ЗҮ:3 Баянбулаг-Тэнгис кинотеатр гэсэн гурван чиглэлийн үйлчилгээг зургадугаар сараас эхлүүлээд байсан билээ. Тэгвэл хүйтний улирал эхэлж, зуслан чиглэлийн зорчигчдын урсгал буурсантай холбоотойгоор дээрх чиглэлүүдийг өчигдрөөс эхлэн зогсоосон байна. Харин хойд чиглэлд байнгын үйлчилгээ үзүүлдэг ХО:2 “Шаргаторьт-Дүнжингарав худалдааны төв”, ХО:1 “Бага баян-Санзай-7 буудал-Тэнгис кино театр” чиглэлийн үйлчилгээ хэвийн үргэлжлэх юм байна.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*“Монгол бичиг номын өв” бүтээлийг танилцуулах ёслол өчигдөр “Их Монгол” оффисын Номын өргөөнд боллоо. Энэхүү номыг Б.Түвшинтөгс, Г.Баттогтох, Д.Боролзой, Ж.Ганбаатар нар бүтээсэн байна. Тус номд Монгол бичгийн анхны биет баримт болох Чингисийн чулууны бичгээс эхлээд Хубилай хааны үүсгэн байгуулсан Юань гүрний төрийн дөрвөлжин бичиг оржээ. Мөн Өндөр гэгээн Занабазарын өөрөө тодорсон үсэг хэмээдэг соёмбо бичиг, маш богино хугацаанд ч гэлээ монголчуудын хэрэглэхийг чармайж байсан латин үсэг, эдүгээ бидний хэрэглэж буй кирилл үсэг хүртэлх бичиг үсгийн түүх, биет дурсгалуудыг багтаасан аж.*

## Хар тамхи хэрэглэж байгаад амиа алджээ

Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт өвс татаж мансуурсан нэгэн иргэн хүргэгдэж ирээд амиа алдсан харамсалтай хэрэг энэ сарын 12-нд гарчээ. Тодруулбал, тус дүүргийн хоёрдугаар хорооны нутаг дэвсгэр орон сууцны хорооллын гадна талбайд Улаанбаатар хотын харьяат 18-22 насны гурван эрэгтэй хар тамхи мансууруулах төрлийн бодис болох каннабисын ургамал татаж мансуурсан аж. Улмаар 18 настай эрэгтэйн гар хөл татаж газарт унаж, ухаан алдахад хамт мансуурч байсан хоёр иргэн түүнийг эмнэлэгт хүргэж өгчээ. Гэвч эмнэлэгт ирээд амьсгал хураасан байна. Тус хэргийг Хан-Уул дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн бөгөөд талийгаачийг нас барах үед хамтдаа хар тамхи мансууруулах бодис хэрэглэж байсан гэх хоёр иргэнийг саатуулан шалгаж байгаа аж.

NO STRESS

ОДДЫН ЦАГ



# СЕЛЕНА ГОМЕЗ: Нүдэндээ хамгийн их ач холбогдол өгдөг

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

*Дуучин, жүжигчин Селена Гомез инстаграмм хуудас, сошиал медиа дахь дагагчдынхаа тоогоор залуу оддыг ардаа хол хаядаг нэгэн. Үргэлж л цахим хуудсаа хөөрхөн царай, үзэсгэлэнт төрхөөрөө чимдэг түүнийг гоо сайхандаа хэрхэн анхаардаг талаар шүтэн бишрэгчид нь сонирхож байсан нь гарцаагүй. Тэгвэл энэ удаагийн “Оддын цаг” буландаа түүний “Revival” аялан тоглолтынхоо үеэр дэлгэсэн ярилцлагыг хүргэе. Эдүгээ аялан тоглолтоосоо завсарлага авч эрүүл мэнддээ анхаарал тавьж буй 23 настай од бүсгүй өдрийн дэглэм, арьсандаа хэрхэн анхаардаг талаар доорх ярилцлагыг өрнүүлжээ.*

**-Таны нэг өдөр хэрхэн эхэлдэг вэ. Энэ асуултаас ярилцлагаа эхлэе?**

-Өглөө 10.00 цаг өнгөртөл унтаж үзээгүй юм байна. Өмнөх орой нь найзуудтайгаа гадуур гарсан, эсвэл амралтын өдөр биш л бол шүү дээ. Миний нэг өдөр иймэрхүү л эхэлдэг. Боссоныхоо дараа өглөөний дасгалаа хийнэ. Мөн надад өглөө бүр хийдэг гурван зуршил байдаг юм. Эхлээд нүүрээ угаагаад, дараа нь хөгжим сонсонгоо бага зэргийн чийгшүүлэгч нүүрэндээ түрхдэг. Миний арьс маш тослог. Өдөр бүр зооглодог тусгай хоол гэж байдаггүй. Өдөр бүр өөр өөр төрлийн хүнсний бүтээгдэхүүн бэлтгэж хэрэглэхийг эрхэмлэдэг. Харин өдрийн төгсгөлд нүүрээ заавал угаадаг. Нүүрээ угаахгүй унтах дургүй. Ер нь багаасаа хэвшсэн зуршил байгаа юм. Жаахан байхдаа үүнд нэг их ач холбогдол өгдөггүй байсан. Гэхдээ одоо бол миний өдрийн хэмнэлийн нэгээхэн хэсэг. Унтахдаа мөн л намуухан хөгжим сонсдог.

**-Үсэндээ яаж анхаардаг вэ?**

-Үсээ өдөр бүр угаагаад байдаггүй. Их угаах нь үсийг гэмтээх муу талтай. Миний зарим найзууд үсээ угаахгүйгээр хоёр ч хоножь чаддаггүй. Харин миний үс шингэн болохоор бохирдохгүй бол үсээ тэднээс олон өдөр угаахгүй байж чадна. Эцэг, эхээс заясан нэг сайн тал юм даа. Гурав дахь өдрөөс үс илүү шулуун маш гоё болж эхэлдэг. Сайн чанарын бүтээгдэхүүн гэсэн үг. Хачин санагдаж магадгүй л юм. Харин дөрөв дэх өдөр нь заавал үсээ угаах хэрэгтэй дээ. Би хуурай үсэнд зориулсан шампунь хэрэглэдэг. Энэ нь үсний чийгшлийг тэнцвэржүүлэхэд тусалдаг юм.

**-Үсэндээ зориулан тусгайлан хэрэглэдэг бүтээгдэхүүн байдаг бол манай уншигчдад сонирхуулаач?**

-Аялан тоглолтын үеэр Pantene Pro-V Airspray Hair Spray-ыг заавал авч явдаг. Миний үсийг гэрэлтсэн өнгөлөг болгохоос гадна хөвсгөр зөөлөн болгодог. Тиймээс тайзан дээр чөлөөтэй явж, үсээ гараараа янзлахад ямар нэг асуудал үүсдэггүй юм. Ер нь үсээ бүх л үед төгс харагдуулахыг хүсдэггүй хүн гэж байдаггүй байх. Би тайзан дээр үсээрээ оролдох дуртай. Мөн Арганы Морокко тостой Pantene Pro-V Smooth Serum-г хэрэглэдэг. Шоуны дараа үүнээс үсэндээ бага зэргийг түрхдэг.

**-Аялан тоглолтынхоо үеэр хуурайшилтаас хэрхэн сэргийлдэг вэ?**

-Миний зарим дуунууд зөөлөн аялгуутай учраас микрофоноо хэт ойр барьсны улмаас эрүүний арьс эмзэг болчихсон. Миний арчлах ёстой хамгийн эхний хэсэг бол яах аргагүй эрүүний хэсэг. Тиймээс тоглолтын дараа нүүрэндээ чийгшүүлэгч түрхэж, маск тавьдаг.

**-Тайзан дээрх нүүр будалтынхаа талаар сонирхуулаач?**

-Нүүр будагчид маань суурь энгэсэг болон чийгшүүлэгчийг хольж, зөвхөн нэг давхарга тавьдаг. Харин нүдэнд маш их ач холбогдол өгдөг. Хүчтэй бор өнгийн нүд зөөлөн уруул гаргахыг эрхэмлэдэг юм. Заримдаа эсрэгээрээ хийх нь ч бий. Би хувцсаа солихдоо нэг минут орчим хугацаа зарцуулдаг бол нүүр хувиргагчид тэр хооронд энгэсэгийг сэргээдэг. Гэхдээ нүдэнд тэр бүр хүрээд байдаггүй.

Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Marina Ganas**



Ойрд Австрали улсад сурахаар сонирхож боловсролын үзэсгэлэнгээр их явсан юм. Тэгээд нэг лекцэнд сууж байтал “Австралийн нийслэл юу вэ” гэж байна. Би Оттова гээд андуураад хэлчихэв. Тэгээд их санаа зовсон юм уу шөнөжин Canberra Canberra Canberra гэж зүүдлээд бүр галзуурлаа би гэдэг хүн. Жинхэнээсээ амандаа хэлээд цочоод сэрсэн чинь найз залуу хажууд “Ганбаяр гэж хэн юм. За хэлчих хэн билээ” гээд асуучихсан байж байдаг юм даа. Бүр нууц хар уу энэ одоо. Хаха.

ОДДЫН АМЬДРАЛ

## Жессика Альба КОМПАНИА ХУДАЛДАНА



Холливудын сайхан бүсгүйчүүдийн нэг жүжигчин Жессика Альба өөрийн байгуулсан “The Honest” гэх компаниа худалдахаар болжээ. Энэ талаар “Wall street journal” сонин мэдээлсэн байна. Жүжигчин бүсгүй нэг тэрбум орчим ам.доллароор компаниа үнэлсэн гэнэ. Эдүгээ хоёр хүүхэд өсгөж буй тэрбээр 2011 онд хүүхдэд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх “The Honest” компаниа байгуулсан байдаг. Ямар нэг химийн хорт бодисгүй цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүн худалдаалах тус компани олны таашаалыг хүртэж, Америкдаа алдаршчээ. Тэгвэл бүсгүйн компанийн нийт үнэлгээ 1-1.7 тэрбум ам.доллар бөгөөд гэр ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Unilever” компани худалдан авахаар яриа хэлцэл хийж байгаа гэнэ.



## София Вергара Эмми авардст “ГАЛ АСААВ”

АНУ-ын Лос Анжелес хотын Микрософт театрт Америкийн телевизийн салбарын шилдгүүдийг тодруулдаг “Эмми авардс” наадам боллоо. Энэхүү ёслолын үйл ажиллагааны улаан хивсний ёслолд урлаг соёлын одод хүрэлцэн ирсэн байх бөгөөд 44 настай София Вергара Версаче брэндийн цагаан өнгийн торгомсог материалтай урт даашинзаар гангарч ирсэн нь олны харцыг булаажээ. Түүний даашинз энэ удаагийн наадмын хамгийн гоё даашинзны тоонд зүй ёсоор багтаж байна. Мөн тэрбээр даашинзтайгаа Lorraine Schwart брэндийн алмаазан шигтгээ бүхий тансаг чимэглэлийг хослуулсан нь төгс зохицож байсан гэнэ. “Форбес” сэтгүүлээс гаргасан жагсаалтад хамгийн үнэтэй жүжигчнээр тодорч байсан бүсгүй энэ онд 43 ам.долларын орлого олсон байдаг. Тэгвэл энэ удаагийн улаан хивсний ёслолд ч тэрбээр “гал асааж”, бусдаасаа өмссөн зүүлснээрээ ийнхүү ялгарч чаджээ.

Улаанбаатарт:

| | Маргааш | Нөгөөдөр |
|---|---|---|
| Өдөр | -9 | -9 |
| Шөнө | -1 | -4 |

Өдрийн зурхай

**Намрын дунд улаагчин тахиа сарын Таван шар мэнгэтэй Хөхөгчин могой өдөр. Ангараг гараг**

**Үс засуулбал:** Сайн нөхөртэй нөхөрлөнө
**Наран ургах, шингэх:** 06:37 - 18:54



**Өдрийн өнгө:** *Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.*

ДУУЛГАХ СОНИН

## “РОМЕО ЖУЛЬЕТТА” жүжгийг 31500 хүн үзжээ

Хүн төрөлхтний агуу хайр сэтгэлийн тухай өгүүлэх У.Шекспирийн“РомеоЖульетта” жүжиг Улсын драмын эрдмийн театрын тайзнаа гурав дахь удаагийн найруулгаар тавигдаад байгаа билээ. Тодруулбал, 1966 онд найруулагч С.Гэндэн, 1996 онд Ч.Найдандорж найруулан тавьж байсан. Тэгвэл энэхүү жүжиг 19 жилийн дараа Монголын театрын тайзнаа Н.Наранбаатарын найруулгаар дахин амилаад буй. Үзэгчдэд хүрсэн цагаасаа эхлэн “Ромео Жульетта” жүжиг шагналын хурыг дагуулж байгаа гэхэд болно. Тус жүжиг “Гэгээн муза” наадмаас зургаан муза хүртэн Гранпри шагналын эзэн болж байсан.

Мөн энэ сарын 11-16-ны өдрүүдэд Буриадын Улан-Үдэ хотноо болсон “Алтан Сэргэ” олон улсын театрын наадамд оролцож, “Шилдэг эрэгтэй дүр”, “Шилдэг эрэгтэй туслах дүр”, “Шилдэг эмэгтэй туслах дүр”, “Шилдэг хөгжмийн зохиолч” номинацид тэргүүлж, шагнал хүртсэн баярт мэдээг дуулгасан билээ.Түүнчлэнэнэхүүбүтээлийг Н.Наранбаатарын найруулгаар 65 удаа тавьсан бөгөөд 31500 хүн үзээд байгаа аж. Сонирхуулахад, “Ромео Жульетта” жүжиг энэ сарын 23-25-нд дахин тоглогдох юм байна.

ТЭНГИС КИНО ТЕАТР




**90-ээд оны үед залуусын дунд нэрд гарч байсан хамтлаг тодорхой шалтгааны улмаас тарцгааж киноны үйл явдал эхэлнэ. Залуус тус тусын амьдралыг хөөж 20 жил өнгөрсний дараа хамтлагийн нэг гишүүн эргэн нэгдэх санал тавьж үйл явдал өрнөх болно. Урлаг тэднийг хүлээн авах болов уу?**




**Артур Бишоп урьд хийдэг байсан ажлаа орхиж тайван амьдрахыг хүссэн боловч түүний дайснууд хайртай бүсгүйг нь олзолно. Яах ч аргагүй байдалд орсон тэрээр дэлхийн талыг туулж 3 том аллага үйлдэх хэрэгтэй болдог. Гэвч энэ бүх ажиллагаа санаандгүй болсон мэт харагдах ёстой.**

